

ДЭЛХИЙН ЗАРИМ ОРНУУДЫН ТӨРИЙН ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГАА

Г.Билгээ, Д.Жигваагүнсэл

УДИРТГАЛ

Захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу дэлхийд Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий хэмжээгээр тэргүүлэгч 15 орон болон нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээгээр тэргүүлэгч 10 орны төрийн байгуулал, гүйцэтгэх засаглал, шүүх засаглалын талаарх мэдээлэл, эрх зүйн системийн аль бүлд хамаардаг тухай мэдээлэл лавлагаа бэлтгэв.

Судалгаанд төрийн байгууллын хувьд Үндсэн хуульт хаант засаглалтай-12 орон, Үндсэн хуульт парламентын засаглалтай-8 орон, Ерөнхийлөгчийн засаглалтай-5 орныг хамруулав.

ДНБ-ийн хэмжээгээр тэргүүлэгч улсууд:

- | | |
|--------------------|---|
| 1. Америк | Холбооны бүгд найрамдах, үндсэн хуульт ерөнхийлөгчийн засаглалтай улс |
| 2. Хятад | Нэг намын тогтолцоотой, парламентын бүгд найрамдах улс |
| 3. Япон | Парламентын засаглалтай үндсэн хуульт хаант улс |
| 4. Герман | Парламентын засаглалтай холбооны улс |
| 5. Франц | Үндсэн хуульт хагас ерөнхийлөгчийн засаглалтай бүгд найрамдах улс |
| 6. Их Британи | Парламентын засаглалтай үндсэн хуульт хаант улс |
| 7. Бразил | Ерөнхийлөгчийн засаглалтай холбооны бүгд найрамдах улс |
| 8. Итали | Парламентын ардчилсан бүгд найрамдах улс |
| 9. Орос | Хагас ерөнхийлөгчийн засаглалтай үндсэн хуульт холбооны улс |
| 10. Энэтхэг | Парламентын бүгд найрамдах холбооны улс |
| 11. Канад | Парламентын засаглалтай үндсэн хуульт хаант улс |
| 12. Австрали | Үндсэн хуульт хаант засагтай, парламентын холбооны улс |
| 13. Испани | Парламентын ардчилсан үндсэн хуульт хаант засаглалтай нэгдмэл улс |
| 14. Өмнөд Солонгос | Парламентын бүгд найрамдах улс |
| 15. Мексик | Ерөнхийлөгчийн засаглалтай холбооны бүгд найрамдах улс |

Нэг хүнд ногдох ДНБ-ийн хэмжээгээр тэргүүлэгч улсууд:

- | | |
|-----------------|--|
| 16. Катар | Үндсэн хуульт хэмжээгүй эрхт хаант засагтай улс |
| 17. Люксембург | Үндсэн хуульт эзэн хаант парламентын ардчилсан улс |
| 18. Сингапур | Парламентын бүгд найрамдах нэгдмэл улс |
| 19. Бруней | Үндсэн хуульт хаант улс |
| 20. Кувейт | Үндсэн хуульт хаант улс |
| 21. Норвеги | Үндсэн хуульт хаант засаглалтай нэгдмэл улс |
| 22. Арабын НЭУ | Үндсэн хуульт хаант улс |
| 23. Сан Марино | Парламентын засаглалтай бүгд найрамдах улс |
| 24. Швейцарь | Парламентын засаглалтай холбооны улс |
| 25. Саудын Араб | Үндсэн хуульт хаант улс |

Эрх зүйн бүлийн хувьд судалгаанд хамрагдсан 25 орны дийлэнх нь буюу 11 орон Ром-Германы эрх зүйн бүлд, 6 орон Англи-Саксоны эрх зүйн бүлд, 3 орон Исламын Шариатын эрх зүйн бүлд хамаарах ба бусад нь холимог эрх зүйн системтэй, социалист, Скандинавын эрх зүйн бүлд тус тус хамаарч байна.

Ром-Германы эрх зүйн бүлд:	Герман, Франц, Бразил, Итали, ОХУ, Испани, Өмнөд Солонгос, Мексик, Люксембург, Швейцарь
Англи-Саксоны эрх зүйн бүлд:	АНУ, Англи, Энэтхэг, Канад, Австрали, Сингапур
Исламын Шариатын эрх зүйд тулгуурласан:	Катар, Кувейт, Саудын Араб
Холимог эрх зүйн системтэй:	Япон, Бруней
Социалист:	БНХАУ
Скандинавын эрх зүйн бүлд:	Норвеги

Судалгааны мэдээллийг бэлтгэхдээ С.Нарангэрэлийн “Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо”⁹⁹, Д.Баярсайханы “Эрх зүйн онол”¹⁰⁰, УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргасан “Дэлхийн улс орнуудын парламент”¹⁰¹ энциклопеди ном болон дэлхийн улс төрийн тогтолцооны гарын авлага “Төр улсуудын засгийн газар”¹⁰² зэрэг эх сурвалжуудыг голлон ашиглав.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

⁹⁹Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001.

¹⁰⁰Баярсайхан Д. Эрх зүйн онол. УБ., 2006.

¹⁰¹Дэлхийн улс орнуудын парламент. УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргасан. УБ., 2010 он.

¹⁰²Төр улсуудын засгийн газар (Дэлхийн улс төрийн тогтолцооны гарын авлага). Монсудар хэвлэлийн газар. 2011.

1. АМЕРИК

Албан ёсны нэр:	Америкийн Нэгдсэн Улс
Хүн ам:	281,4 сая
Нийслэл:	Вашингтон
Нутаг дэвсгэр:	9,626,091 км ²
Тусгаар тогтносон он:	1776
Үндсэн хууль баталсан он:	1787
Засаг захиргааны нэгж:	50 муж улс, Колумбын холбооны тойрог
Харьяа газар нутаг:	Самао, Бэйкэр арал, Гуам, Ховландын арал, Жарвисын арал, Жонстон Атол, Кингман Рийф, Мидвэй арлууд, Навассын арлууд, хойд Марианы арлууд, Палмира атол, Пуэрто Рико, Виржиний арлууд, Вэйк арал
Эрх зүйн бүл:	Англи-Саксоны ¹⁰³

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
<p>Конгресс Хоёр танхимтай.</p> <p>➤ Сенат Дээд танхим нь бүх нийтийн сонгуулиар 6 жилийн хугацаагаар сонгогдсон 100 гишүүнтэй. Муж улс бүрээс 2 гишүүн сонгогддог ба 2 жил тутам 1/3 нь шинээр сонгогдоно. 16 байнгын хороотой.</p> <p>➤ Төлөөлөгчдийн танхим Доод танхимын 435 гишүүдийг 2 жилийн хугацаатайгаар бүх нийтийн сонгуулиар сонгоно. Танхим 21 мэргэжсэн байнгын хороотой.</p> <p>Муж улсуудын засаг захиргаа 50 муж улс, 1 холбооны тойрог, хилийн чанад дахь 14 газар нутагтай. Хууль тогтоох хоёр танхимын гишүүдийг бүх нийтийн сонгуулиар сонгоно. Муж улсуудын гүйцэтгэх засаглалыг захирагчид захирна.</p>	<p>Ерөнхийлөгч Муж улс болгоноос шууд сонгогдсон сонгогчдоос бүрдсэн Сонгогчдын коллегийн саналаар 4 жилийн хугацаатай сонгогдох бөгөөд нэг удаа улиран сонгогдох эрхтэй. Тэрээр төр, засгийн тэргүүн бөгөөд зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.</p> <p>➤ Дэд Ерөнхийлөгч Ерөнхийлөгчийн адил жишгээр 4 жилийн хугацаатай сонгогдох ба тэрээр гүйцэтгэх засаглалын бодлогыг хэрэгжүүлэхэд Ерөнхийлөгчид тусална.</p> <p>➤ Сайд нарын танхим Танхимын 15 гишүүнийг Ерөнхийлөгч томилж, Сенат батална.</p> <p>➤ Гүйцэтгэх агентлагууд Гүйцэтгэх засаглалын хамгийн чухал салбар бөгөөд Конгрессоос эрх, үүргийг тодорхойлдог.</p>	<p>Дээд шүүх 9 гишүүнийг бүх насаар нь Ерөнхийлөгч томилж, Сенат батална. Дээд шүүх нь холбооны ба муж улсуудын хууль, шүүхэд хяналт тавих, шүүхийн эцсийн шатны шийдвэрийг гаргах шүүхийн дээд байгууллага. Түүнчлэн бодлого боловсруулагчид, тодорхой зэрэг дэвт хамааралтай аливаа асуудлыг хуулийн үүднээс хянан шалгах үүрэгтэй.</p> <p>➤ Нэгдсэн улсын давж заалдах шүүх Муж улс бүрт байх ба холбооны шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.</p> <p>➤ Нэгдсэн улсын тойргийн шүүх Холбооны анхан шатны шүүхүүд хамаарна.</p> <p>➤ Муж улсын шүүх Муж улсуудын Үндсэн хуулийн дагуу мужийн шүүгчид удирдана.</p> <p>➤ Анхан шатны шүүх Тойргийн шүүхийг удирдана.</p>

¹⁰³Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 227 дахь тал.

2. ХЯТАД

Албан ёсны нэр:	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
Хүн ам:	1,29 тэрбум
Нийслэл:	Бээжин
Нутаг дэвсгэр:	9,596,960 км ²
Тусгаар тогтносон он:	МЭӨ 221
Үндсэн хууль баталсан он:	1982
Засаг захиргааны нэгж:	23 муж, 5 автономит улс, 4 бие даасан хот
Харьяа газар нутаг:	Байхгүй
Эрх зүйн бүл:	Социалист ¹⁰⁴

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
<p>Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал</p> <p>Нэг танхимтай. ХКН¹⁰⁵-ын төлөвлөгөөг хэлэлцэнэ. 5 жил тутамд бүх Хятад, АЧА¹⁰⁶-аас сонгогдсон 2,900-гаад гишүүдтэй, саяханаас илүү бие даах болсон. Төрийн бодлого боловсруулах, төсөв батлах, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, өндөр тушаалын түшмэдийг томилно. Ихэнх нь ХКН-ын гишүүд байна.</p> <p>➤ Байнгын хороо</p> <p>160-аад гишүүдтэй. Тогтмол хуралдана. Хууль санаачлах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулдаг ч голдуу намын боловсруулсан хуулийн төслийг баталдаг. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах эрхтэй.</p> <p>Муж, орон нутгийн засаг захиргаа</p> <ul style="list-style-type: none">Муж, хот, жижиг хотын АИХ¹⁰⁷-ын төлөөлөгчдийг түүнээс доод шатны АИХ-ын сонгуулиар сонгох ба Төв Засгийн газраас шууд хамааралтай.Сонгогдсон дарга, захирагч нар хотыг захирна.	<p>БНХАУ-ын дарга буюу төрийн тэргүүнийг ХКН-аас нэр дэвшүүлж, БХАТИХ-аар батлан 5 жилийн хугацаатай томилдог бөгөөд нэг л удаа улируулан сонгодог. Тэрээр ХКН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, ХКН-ын Цэргийн зөвлөлийн даргын үүргийг гүйцэтгэх ба өршөөлийн зарлиг гаргах, дайн зарлах болон Ерөнхий сайдыг томилох эрхтэй.</p> <p>➤ Орлогч дарга</p> <p>➤ Ерөнхий сайд нь Төрийн зөвлөл буюу Засгийн газрын тэргүүн бөгөөд БХАТИХ-аас томилогдоно.</p> <p>➤ Төрийн зөвлөл нь БХАТИХ-аас сонгон томилсон Ерөнхий сайд, Орлогч дарга, Төрийн зөвлөхүүд, яамдын сайд нар, зөвлөлийн тэргүүн нар, Ерөнхий аудитор, Ерөнхий нарийн бичгийн дарга зэрэг хариуцлагатай албан тушаалтнуудаас бүрдэнэ.</p>	<p>Ардын дээд шүүхийн ерөнхий шүүгчийг БХАТИХ-аас томилдог ба нэг л удаа улируулан томилно. Бусад шүүгчдийг БХАТИХ-ын Байнгын хороо томилно. Энэ бол давж заалдах шатны эцсийн шүүх байгууллага. Нам төрийн зорилгод хамааралтай байж, дотроо гэмт хэрэг, иргэний хэрэг, эдийн засгийн хэргийн салбаруудтай.</p> <p>➤ Ардын дээд прокурорын газар нь шүүх ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэхийг хянах үүрэгтэй.</p> <p>➤ Ардын доод шатны шүүх нь Ардын дээд шүүх, Ардын дунд шүүх, Ардын үндсэн шүүхээс бүрддэг ба доод шатны прокурорын газар нь дотроо иргэний, гэмт хэргийн, засаг захиргааны, эдийн засгийн салбаруудтай.</p> <p>➤ Ардын тусгай шүүх буюу Цэргийн шүүх нь цэргийн гэмт хэрэг шийдвэрлэнэ.</p>

¹⁰⁴Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 302 дахь тал.
¹⁰⁵ХКН – Хятадын коммунист нам
¹⁰⁶АЧА – Ардын чөлөөлөх арми
¹⁰⁷АИХ – Ардын их хурал

3. ЯПОН

Албан ёсны нэр:	Япон
Хүн ам:	127,3 сая
Нийслэл:	Токио
Нутаг дэвсгэр:	377,835 км ²
Тусгаар тогтносон он:	МЭӨ 660
Үндсэн хууль баталсан он:	1947
Засаг захиргааны нэгж:	47 муж
Харьяа газар нутаг:	Байхгүй
Эрх зүйн бүл:	Холимог (Япон, Филиппиний) ¹⁰⁸

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
<p>Үндэсний зөвлөл (парламент)</p> <p>нь хоёр танхимтай. Танхимуудын дунд маргаан гарвал Төлөөлөгчдийн танхим давуу эрхтэй.</p> <p>➤ Зөвлөхүүдийн танхим</p> <p>Нийт 242 гишүүнийг холимог системээр сонгоно. 142 гишүүнийг 62-10 мандат бүхий 47 тойргоос, үлдсэн 100 гишүүнийг үндэсний хэмжээнд нэг тойрог болгон тус тус сонгодог байна. Бүрэн эрхийн хугацаа 6 жил. 3 жил тутамд гишүүдийн хагас нь шинээр сонгогддог.</p> <p>➤ Төлөөлөгчдийн танхим</p> <p>4 жилийн хугацаатай сонгогдсон 480 гишүүдтэй. Төлөөлөгчдийн танхимыг хугацаанаас нь өмнө татан буулгах эрх зүйн зохицуулалт бий. Тус танхимын нийт гишүүдийн 300 нь сонгуулийн тойргоос нэг суудлын төлөө өрсөлддөг бол бусад 180 гишүүн нь намын жагсаалтын системээр 11 мужуудаас сонгогдоно.</p> <p>Орон нутгийн засаг захиргаа</p> <ul style="list-style-type: none"> Захирагч буюу Мэрүүдийг сонгодог Өөрсдийн чуулгантай. 	<p>Эзэн хаан</p> <p>Угсаа залгамжлагч, төрийн тэргүүн бөгөөд гүйцэтгэх засаглалыг удирдахгүй. Түүний хязгаарлагдмал эрх мэдэл Зөвлөлийн болон Сайд нарын танхимын зөвшөөрлөөр хэрэгжинэ. Тэрээр Ерөнхий сайд, Ерөнхий шүүгч, Сайд нарын танхимын гишүүдийг томилж, Үндсэн хуульд өөрчлөлт, засвар оруулахыг зарлах, Төлөөлөгчдийн танхимыг тараах, Үндэсний зөвлөлийг зарлан хуралдуулах эрхтэй.</p> <p>Ерөнхий сайд</p> <p>Тэргүүнийг ихэвчлэн Төлөөлөгчдийн танхимд олонх болсон нам, эвслийн гишүүдээс Үндэсний зөвлөлийн нууц санал хураалтаар сонгоно. Тэрээр өөрийн танхимын гишүүдийг сонгож, Эзэн хаан 4 жилийн хугацаатай томилдог.</p> <p>➤ Сайд нарын танхим</p> <p>Ерөнхий сайд даргалж, Үндсэн хуулийн дагуу 14 гишүүнийг томилох ба тэдний гурвыг нь тусгай гишүүдээр томилж болно. Ерөнхий сайд хүсвэл гишүүдийн талыг нь Зөвлөлөөс томилно.</p>	<p>Дээд шүүх</p> <p>Шүүх засаглалын дээд байгууллага. Ерөнхий шүүгчийг Эзэн хаан Танхимын санал болгосноор томилдог. Бусад 14 шүүгчийг Танхимаас сонгоно. Дээд шүүхийн шүүгчид Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хэрэгжилт, гүйцэтгэх засаглалын дүрэм, журам, тогтоолуудад шүүх засаглалын зүгээс хяналт тавих эрхтэй. Доод шатны шүүхийг баталгаажуулах, гарсан шийдвэрийг Үндсэн хуулинд нийцүүлэн эцсийн шийдвэрийг гаргана.</p> <p>➤ Танхимын дээд шүүх</p> <p>Бүрэлдэхүүнд нь 8 шүүгч орох ба тэднийг Дээд шүүхийн дэвшүүлсэн саналын дагуу Сайд нарын танхим томилно. Тэд анхан шатны шүүхийн биелэлтийг хариуцна.</p> <p>➤ Гэр бүлийн шүүх</p> <p>50 дүүрэг ба гэр бүлийн шүүхийн шүүгчдийг Дээд шүүхийн саналын дагуу Сайд нарын танхим томилно. Тэд иргэний ба эрүүгийн хэргийн шийдвэр, тухайлбал хөнгөн ба хүнд шийтгэл, торгууль, бусад нэхэмжлэл, заргыг хамтдаа барагдуулах үүрэгтэй.</p> <p>➤ Дүгнэлтийн шүүх</p> <p>438 шүүхтэй бөгөөд шүүгчдийг нь Дээд шүүхийн саналаар Сайд нарын танхим томилно.</p>

¹⁰⁸Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 302 дахь тал.

4. ГЕРМАН

Албан ёсны нэр:	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
Хүн ам:	82 сая
Нийслэл:	Берлин
Нутаг дэвсгэр:	357,021 км ²
Тусгаар тогтносон он:	1871
Үндсэн хууль баталсан он:	1949
Засаг захиргааны нэгж:	16 холбооны муж
Харьяа газар нутаг:	Байхгүй
Эрх зүйн бүл:	Ром-Германы ¹⁰⁹

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
<p>Холбооны парламент</p> <p>Хоёр танхимтай.</p> <p>➤ Бундесрат</p> <p>Парламентын дээд танхим бөгөөд 16 муж улсуудын Засгийн газруудаас сонгогдсон 69 төлөөлөгчидтэй, муж улс бүр 3-6 төлөөлөгчдийг томилно.</p> <p>➤ Бундестаг</p> <p>Парламентын доод танхим бөгөөд 4 жилийн хугацаатай сонгогдсон 662 гишүүнтэй. Бундестаг Германы Канцлерыг 4 жилийн хугацаатай сонгон томилдог.</p> <p>Орон нутгийн засаг захиргаа</p> <p>16 муж улсын засаг захиргаа нь тус бүрдээ сонгогдсон хууль тогтоох байгууллагатай.</p>	<p>Канцлер</p> <p>Засгийн газрын тэргүүнийг Ерөнхийлөгчийн санал болгосноор Бундестагаас сонгож, Ерөнхийлөгч томилно. Канцлер нь Танхимынхаа сайд нарыг санал болгон, дотоодын улс төрийн бодлогыг хэрэгжүүлдэг. Ерөнхийлөгчид санал зөвлөмж өгдөг.</p> <p>Ерөнхийлөгч</p> <p>Холбооны Ерөнхийлөгч нь Холбооны хурлаас 5 жилийн хугацаатай сонгогдоно. Холбооны хурал нь Бундестагийн гишүүд, түүнтэй тэнцүү тооны муж улсын төлөөлөгчдөөс бүрдсэн онцгой байгууллага бөгөөд гагцхүү Холбооны Ерөнхийлөгчийг сонгох эрхтэй. Ерөнхийлөгч нь билэг тэмдгийн шинжтэй ба тэрээр олон улсын гэрээ батлах ба гадаадад эх орноо төлөөлдөг.</p> <p>➤ Танхим</p> <p>Танхим нь Канцлер болон холбооны сайдуудаас бүрдэнэ. Танхимын гишүүдийг Канцлерийн санал болгосноор Ерөнхийлөгч томилно.</p>	<p>Холбооны Үндсэн хуулийн шүүх</p> <p>Холбооны шүүх болон бусад гишүүдээс бүрдэнэ. Шүүгчдийг Бундестаг болон Бундесратаас тэнцүү тоогоор сонгоно. Холбооны Үндсэн хуулийн шүүх нь Холбооны Үндсэн хуультай холбоотой бүх маргааныг шийдэх эрхтэй. Муж улсууд нь өөрсдийн Үндсэн хуулийн шүүхтэй бөгөөд энэ нь өөрийн Үндсэн хуульд хамараах, түүнийг зөрчиж эсэх маргааныг шийдвэрлэдэг.</p> <p>➤ Холбооны шүүх</p> <p>➤ Муж улсуудын шүүх</p>

¹⁰⁹Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 240 дэх тал.

5. ФРАНЦ

Албан ёсны нэр:	Бүгд Найрамдах Франц Улс
Хүн ам:	547,030 сая
Нийслэл:	Парис
Нутаг дэвсгэр:	547,030 км ²
Тусгаар тогтносон он:	486
Үндсэн хууль баталсан он:	1958
Засаг захиргааны нэгж:	22 муж
Харьяа газар нутаг:	4 харьяа бүс, далайн чанад дахь 4 газар нутаг, тусгай статустай 2 газар нутаг
Эрх зүйн бүл:	Ром-Германы ¹¹⁰

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
<p>Парламент</p> <p>Хоёр танхимтай.</p> <p>➤ Сенат</p> <p>Дээд танхим нь шууд бус сонгогчдын коллегийос сонгогдсон 348 гишүүнтэй.</p> <p>Сенатуудын 1/3 нь 3 жил тутамд шинээр сонгогдоно.</p> <p>➤ Үндэсний ассамблей</p> <p>Доод танхимын 577 гишүүн 5 жилийн хугацаатайгаар бүх нийтийн сонгуулиар сонгогдоно.</p> <p>Орон нутгийн засаг захиргаа</p> <ul style="list-style-type: none"> 22 муж засаг захиргааны 96 нэгжүүд нь яам тамгын газрын хэлтсүүд нутаг дэвсгэр болон хамтын нөхөрлөлийн үйл ажиллагааг хянана 	<p>Ерөнхийлөгч</p> <p>7 жилийн хугацаатай сонгогдоно. 30 гаруй нэгж, харьяа нутаг дэвсгэрээс 500 гаруй дэмжигчийн гарын үсэгтэй санал цуглуулан албан ёсоор нэр дэвших эрхийг авна. Тэрээр олон улсын хэлэлцээр батлах, Ерөнхий сайдыг томилох, Үндэсний ассамблейг тараах бүрэн эрхтэй ба Сайд нарын зөвлөлийг тэргүүлэх, Шүүхийн дээд зөвлөлийг удирдах, Францын төрийн дээд албан тушаалтан.</p> <p>Ерөнхий сайд</p> <p>Засгийн газрын тэргүүн нь парламентад олонх болсон нам эвслээс нэр дэвшин сонгогдох ба Ерөнхийлөгч тодорхой бус хугацаагаар томилно. Ерөнхий сайд нь Засгийн газрыг удирдах ба түүний үүрэг хариуцлагыг тусган танхимын гишүүдийн зүгээс Ерөнхийлөгчид санал дэвшүүлнэ.</p> <p>➤ Сайд нарын танхим</p> <p>Танхимыг Ерөнхийлөгч даргалаж, Ерөнхий сайд тэргүүлнэ. 15 гүйцэтгэх агентлагуудаас бүрдэнэ.</p>	<p>Дээд шүүх</p> <p>Шүүхийн дээд байгууллага ба шүүгчдийг Ерөнхийлөгч томилно. Дээд шүүх нь иргэний, эрүүгийн, нийгмийн, арилжааны, эдийн засгийн, санхүүгийн хуулийн хэргийг шүүх үндсэн 6 танхимд хуваагдана. Анхан шатны шүүхийн шийдвэр, дүгнэлтийг хянах, ямар нэгэн хуулийн хүрээнд хамаарах хэргүүдийг шүүн шийдвэрлэнэ.</p> <p>➤ Үндсэн хуулийн зөвлөл</p> <p>9 гишүүнтэй, Ерөнхийлөгчийг нь ээлжлэн сонгоно: Сенатын ерөнхийлөгч, Үндэсний ассамблейн ерөнхийлөгч тус тус 3 жилийн хугацаатай тэргүүлнэ.</p> <p>Зөвлөл нь Ерөнхийлөгчийн, Парламентын сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх, дүнг нийтэд зарлах, Парламентаар хэлэлцэгдэж байгаа хуулийн төсөл, эсхүл шинээр батлагдсан хуулийг хянан үзэж Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах, хэрэв Үндсэн хуультай зөрчилдсөн тохиолдолд нийтлүүлэхийг хойшлуулах эрхтэй.</p>

¹¹⁰Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 240 дэх тал.

6. ИХ БРИТАНИ

Албан ёсны нэр:	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс
Хүн ам:	59.5 сая
Нийслэл:	Лондон
Нутаг дэвсгэр:	244.820 км ²
Тусгаар тогтносон он:	1707
Үндсэн хууль баталсан он:	Тэмдэглэгдээгүй
Засаг захиргааны нэгж:	Англи-47 хот, Умард Ирланд-24 тойрог, Шотланд-32 зөвлөлийн муж, Уэльс-11 гүнгийн харьяат хот
Харьяа газар нутаг:	15 газар нутаг
Эрх зүйн бүл:	Англи-Саксоны ¹¹¹

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
<p>Парламент</p> <p>Хоёр танхимтай.</p> <p>➤ Лордын танхим</p> <p>670 гаруй гишүүнтэй, тэдний 92 нь угсаа залгамжлагч язгууртнууд, 26 нь хамба лам нар, 550 гаруй нь язгууртнууд байна. Засгийн газарт асуулт тавих, шүүмжлэн хэлэлцэх эрхтэй ба мөнгөний асуудлаас бусад хууль тогтоомжийг санаачлах, хууль тогтоомжийг 1 жил хүртэл хугацаагаар хойшлуулах эрхтэй.</p> <p>➤ Нийтийн танхим</p> <p>Бүх нийтийн сонгуулиар сонгогдсон 659 гишүүдийн 529 нь Англи, 72 нь Шотланд, 40 нь Уэльс, 18 нь Умард Ирландаас тус тус сонгогдоно. Бүрэн эрхийн хугацаа 5 жил. Танхим нь дангаараа хууль санаачлах, татвар, төсвийн зардлын тухай хуулийн төслийг танилцуулна.</p> <p>Мужуудийн парламент</p> <ul style="list-style-type: none"> Шотландын парламент-129 гишүүнтэй Умард Ирландын ассамблей-108 гишүүнтэй Уэльсийн Үндэсний ассамблей-60 гишүүнтэй 	<p>Эзэн хаан</p> <p>Төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Английн сүмийн тэргүүн, угсаа залгамжилсан, бэлгэ тэмдгийн шинжтэй. Эзэн хаан олон улсын гэрээнд гарын үсэг зурах, парламент, шүүх байгууллагын зарим албан тушаалтныг томилох, Ерөнхий сайдтай 7 хоног тутам уулзах, парламентыг тараах эрхтэй.</p> <p>Ерөнхий сайд</p> <p>Парламентад олонхын суудалтай намын тэргүүн сонгогдох ба тэрээр Засгийн газрын тэргүүлж, гишүүдийг томилох, төрийн албаны үйл ажиллагааг удирдах үүрэгтэй.</p> <p>Сайд нарын танхим</p> <p>20 сайд, Засгийн газрын харьяа агентлагуудын дарга нараас бүрдэнэ. Ерөнхий сайд өөрийн танхимын гишүүдийн тоог яг нарийн тодорхойлж томилох ба тэд Парламентын гишүүд байх ёстой.</p> <p>➤ Засгийн газар</p> <p>Эх баригч намаас сонгогдсон 100 гаруй гишүүн буюу танхимын гишүүд, сайд нар, тэдний нарийн бичгийн дарга нар, шадарлагч, шадар туслахууд болон цөөн тооны язгууртануудаас бүрдэнэ.</p>	<p>Үндсэн хуулийн асуудал хариуцсан газар</p> <p>Шүүх засаглалын дээд байгууллага. Английн эрх зүйн тогтолцоог шинэчлэх, Дээд шүүх байгуулах болон Шотланд, Уэльс, Умард Ирландын Үндэсний шүүх байгуулах ажлыг гүйцэтгэх зорилгоор саяхан байгуулагджээ.</p> <p>➤ Давж заалдах шүүх</p> <p>Эзэн хааны шүүхээс ирсэн эрүүгийн хэрэг, Дээд шүүх, мужийн шүүх, тусгай шүүхээс ирсэн гэмт хэргүүдийг хянан шийдвэрлэнэ.</p> <p>➤ Дээд шүүх</p> <p>Гэрээ хэлэлцээр, худалдаа, иргэний, зохиогчийн эрхийн хэргүүдийг шүүн таслана.</p> <p>Муж, дүүргийн шүүх</p> <p>Эзэн хааны шүүх, Мужийн шүүх, Зөвлөлийн шүүхийн шүүгчид удирдана. Шүүгчид нь газар, татвар, тэтгэвэр тэтгэмж, нийгмийн аюулгүй байдал, цагаачлалын асуудлаар гаргасан шийдвэрийг сонсох, шүүн хэлэлцэнэ. Шүүхийн томилгооны хорооноос шүүгчдийг томилох ба Шотланд, Умард Ирланд, Уэльсийн шүүхүүд нь бие даасан байна.</p>

¹¹¹Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 227 дахь тал.

7. БРАЗИЛ

Албан ёсны нэр:	Холбооны Бүгд Найрамдах Бразил Улс
Хүн ам:	172,6 сая
Нийслэл:	Бразилиа
Нутаг дэвсгэр:	8,456,503 км ²
Тусгаар тогтносон он:	1822
Үндсэн хууль баталсан он:	1988
Засаг захиргааны нэгж:	26 муж улс, 1 холбооны дүүрэг
Харьяа газар нутаг:	Байхгүй
Эрх зүйн бүл:	Ром-Германы ¹¹²

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
<p>Үндэсний Конгресс</p> <p>Хоёр танхимтай.</p> <p>➤ Төлөөлөгчдийн танхим</p> <p>513 суудалтай, гишүүд нь бүх нийтийн сонгуулиар муж, холбооны дүүрэг бүрээс 4 жилийн хугацаатай сонгогдоно. Муж улс бүрээс 8-60 хүртэлх төлөөлөгчдийг сонгоно.</p> <p>➤ Холбооны сенат</p> <p>81 суудалтай, муж улс, холбооны дүүрэг бүрээс 3 гишүүнийг бүх нийтийн сонгуулиар сонгоно. Гишүүд нь 8 жилийн хугацаатай сонгогдоно. Нийт гишүүдийн 1/3 нь 4 жил тутамд шинээр сонгогдоно.</p> <p>Орон нутгийн засаг захиргаа</p> <p>Муж улсууд тус бүр Чуулгантай. Захирагч нар муж улсуудыг удирдана. Түүнчлэн өөртөө засах хотын зөвлөлтэй.</p>	<p>Ерөнхийлөгч</p> <p>4 жилийн хугацаатай бүх нийтийн сонгуулиар сонгогдох ба 1 удаа улируулан сонгох эрхтэй. Ерөнхийлөгч нь 35-аас дээш насны Бразил үндэстэн байна. Тэрээр төр, засгийн тэргүүн бөгөөд Холбооны сенатын зөвшөөрөлтэйгээр Төв Банкны захирал, Ерөнхий өмгөөлөгч, Дээд шүүхийн шүүгчид, элчин сайдууд зэрэг нийт 48.000 албан хаагчид, тушаалтнуудыг томилох эрх мэдэлтэй. Тэрээр зарлиг тогтоол гаргах, хууль санаачлах, хуулийг дэлгэрүүлэх эрхийг мөн эдэлнэ.</p> <p>➤ Дэд Ерөнхийлөгч</p> <p>Ерөнхийлөгчийн нэгэн адилаар бүх нийтийн сонгуулиар 4 жилийн хугацаатай сонгогдоно. Нэг удаа улиран сонгогдож болно. Тэрээр гүйцэтгэх засаглал, захиргааг удирдахад Ерөнхийлөгчид туслалцаа үзүүлнэ.</p> <p>➤ Сайд нарын Танхим</p> <p>Гишүүдийн тоо янз бүр байна. Ерөнхийлөгч танхимыг томилох, татан буулгах эрхтэй.</p>	<p>Холбооны улсын дээд шүүх</p> <p>Шүүхийн дээд байгууллагын удирдлага нь хууль эрх зүй, Үндсэн хуулийн зохих сургалт дүүргэсэн, дадлага туршлагатай 11 шүүгчдээс бүрдэнэ. Шүүгчдийг Холбооны сенат нэр дэвшүүлж, Ерөнхийлөгч бүх насаар нь томилно.</p> <p>➤ Шударга ёсны дээд шүүх</p> <p>Засгийн газрын эсрэг үүсгэсэн шүүхийн тогтоол, гэмт хэргийн үндэслэлтэй хуулийн шийдвэрийг шүүн шийдвэрлэх байгууллага. Нийт 35 шүүгчдээс бүрдэнэ. Гишүүдийг Холбооны сенатаас батламжилсанаар Ерөнхийлөгч томилно.</p> <p>➤ Муж улсын шүүх</p> <p>Муж улс бүрийн нийслэлүүд болон Холбооны дүүрэг шүүхтэй байна. Орон нутгийн шүүхийн үйл ажиллагаанд хяналт тавина. Шүүх бүр хамгийн багадаа 7 шүүгчтэй байдаг.</p>

¹¹²Дэлхийн улс орнуудын парламент. УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргасан. УБ., 2010 он. 265 дахь тал.

8. ИТАЛИ

Албан ёсны нэр:	Бүгд Найрамдах Итали Улс
Хүн ам:	57,5 сая
Нийслэл:	Ром
Нутаг дэвсгэр:	301,230 км ²
Тусгаар тогтносон он:	1861.03.17
Үндсэн хууль баталсан он:	1948.01.01
Засаг захиргааны нэгж:	20 муж
Харьяа газар нутаг:	Байхгүй
Эрх зүйн бүл:	Ром-Германы ¹¹³

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
<p>Парламент</p> <p>Хоёр танхимтай ба танхимууд нь ижил тэнцүү эрхтэй. Аливаа хууль батлагдахдаа хоёр танхимаар хэлэлцэгдсэн байна.</p> <p>➤ Сенат</p> <p>Нийт 324 гишүүдтэй. Гишүүдийг пропорциональ системээр 5 жилийн хугацаатай сонгоно.</p> <p>➤ Төлөөлөгчдийн танхим</p> <p>Нийт 630 гишүүдтэй. Гишүүдийг пропорциональ системээр 5 жилийн хугацаатай сонгоно.</p> <p>Орон нутгийн засаг захиргаа</p> <p>Засаг захиргааны 5 автономит дүүрэг, 20 муж, 105 тойрогт сонгогдсон Зөвлөлүүд ажиллана.</p>	<p>Ерөнхийлөгч</p> <p>Парламентаам 7 жилийн хугацаатайгаар сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч ба Парламентад хуулийн төслийг дахин хэлэлцүүлэхээр буцаах, Парламентын хоёр танхимыг тараах эрхтэй.</p> <p>Ерөнхий сайд</p> <p>Ерөнхийлөгч нэр дэвшүүлж, Парламент батална. Тэрээр Засгийн газрын тэргүүн ба Засгийн газрын хэрэгжүүлж буй бодлого, сайд нарын үйл ажиллагаанд хяналт тавих, зохицуулалт хийх эрхтэй.</p> <p>➤ Сайд нарын зөвлөл</p> <p>Сайд нарыг Ерөнхий сайдын зөвлөснөөр Ерөнхийлөгч нэрийг нь дэвшүүлж, Парламент батална.</p>	<p>Дээд шүүх</p> <p>Италийн шүүх засаглалын хяналт тавих дээд байгууллага. Дээд шүүх нь доод, анхан шатны шүүхээс гаргасан дүрэм журамд дахин хяналт, тодотгол хийж иргэний ба эрүүгийн хэргийг шийдвэрлэх эрх мэдэлтэй. Бусад жирийн хэргүүдийн хувьд 10 хэсэгт буюу 6 эрүүгийн, 3 иргэний, 1 ажил эрхлэгчдийн маргааныг шүүн таслах шүүхэд хуваагдана.</p> <p>➤ Үндсэн хуулийн шүүх</p> <p>15 гишүүнийг 9 жилийн хугацаатайгаар сонгож, тэдний 1/3 хувийг нь Ерөнхийлөгч, 1/3 хувийг Парламент, 1/3 хувийг нь шүүх томилно. Үндсэн хуулийн шүүх нь ямар нэгэн хууль үндсэн хуультай зөрчилдөж байгааг батласан бол Ерөнхийлөгчийн дэмжлэгтэйгээр алдааг засаж, шийдвэрлэнэ.</p> <p>➤ Анхан шатны шүүх</p> <p>Иргэний, эрүүгийн хэргийн шүүгчдийг мэргэжлийн сонгон шалгаруулалтаар өрсөлдүүлэн авдаг ба хамгийн өндөр оноо авсан нь даргалах журамтай.</p>

¹¹³Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 240 дэх тал.

9. ОРОС

Албан ёсны нэр:	Оросын Холбооны Улс
Хүн ам:	144,7 сая
Нийслэл:	Москва
Нутаг дэвсгэр:	17,075,184 км ²
Тусгаар тогтносон он:	1991
Үндсэн хууль баталсан он:	1993
Засаг захиргааны нэгж:	21 бүгд найрамдах улс, 68 бусад засаг захиргааны нэгж
Харьяа газар нутаг:	Байхгүй
Эрх зүйн бүл:	Ром-Германы ¹¹⁴

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
<p>Холбооны хурал</p> <p>Хоёр танхимтай. Холбооны зөвлөл нь Төрийн Думын баталсан хуулийн төслийг хэрэгсэхгүй болгох эрхтэй. Дум тухайн хуулийн төслийг 2 дахь удаагаа хэлэлцэж дийлэнх олонхоор баталсан бол түүнд нэмэлт, өөрчлөлт оруулна.</p> <p>➤ Холбооны зөвлөл</p> <p>Дээд танхимд ОХУ-ын субъект нэг бүрээс 2 төлөөлөгч, субъектүүдын төрийн захиргаа, гүйцэтгэх байгууллагаас тус бүр 1 төлөөлөгчийг 4 жилийн хугацаатай сонгоно. Ерөнхийлөгчийн сонгуулийг зарлах, түүнийг огцруулах, хилийн өөрчлөлтийг батлах, Думаас гаргасан хуульд хориг тавих, батлах эрхтэй.</p> <p>➤ Төрийн Дум</p> <p>Доод танхимын 450 гишүүнийг 4 жилээр сонгоно. Тэдний хагас нь сонгуулийн тойргуудаас, хагас нь намын жагсаалтаар сонгогдоно. Засгийн газарт хяналт тавих, Төв банкны дарга, сайд нарыг томилох, үндэсний төсөв, хууль батлана.</p> <p>Орон нутгийн засаг захиргаа</p> <p>21 бүгд найрамдах улс, 68 муж, дүүргийг сонгогдсон мужийн Зөвлөл, Ерөнхийлөгч болон Захирагч нар удирдана.</p>	<p>Ерөнхийлөгч</p> <p>Бүх нийтийн сонгуулиар 6 жилийн хугацаатай сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн, Үндэсний аюулгүйн зөвлөлийн дарга, Зөвсэгт хүчний ерөнхий командлагч ба улс орны үндсэн бодлогыг хэрэгжүүлэх, шүүх засаглалын эцсийн шийдвэр гаргаж, шүүгчийн үүрэг гүйцэтгэх, элчин сайдыг томилох, төрийн аюулгүй байдлыг хангах, сонгуулийг зарлах, парламентыг тараах эрхтэй.</p> <p>➤ Ерөнхийлөгчийн алба</p> <p>Аюулгүй байдлын зөвлөл, Батлан хамгаалах зөвлөл, Засгийн газрын хэрэг эрхлэх газар зэрэг хамаарах ба тэдгээр нь Ерөнхийлөгчийг Засгийн газрын бодлогын хэрэгжилтийг удирдах, зарлиг, тогтоолыг төсөвлөх зэрэгт туслалцаа үзүүлнэ.</p> <p>Ерөнхий сайд</p> <p>Ерөнхийлөгч Ерөнхий сайдыг нэр дэвшүүлж, Төрийн Дум батална. Тэрээр Засгийн газрын тэргүүн ба Ерөнхийлөгчийн удирдлагад ажиллах ба 8 орлогчтой. Сайд нарын танхимыг бүрдүүлж, Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу Засгийн газрын өдөр тумын үйл ажиллагааг удирдана.</p> <p>➤ Сайд нарын зөвлөл</p> <p>Яам, агентлаг, удирдах газрууд, Ерөнхий сайд, түүний орлогчдоос бүрдэнэ.</p>	<p>Үндсэн хуулийн шүүх</p> <p>19 гишүүнээс бүрдэх ба тэднийг Ерөнхийлөгч санал болгосноор Холбооны зөвлөл бүх насаар нь томилно. Баталсан хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, чиглэл, орон нутгийн үндсэн хууль, журам, хууль эрхийн актууд нь үндсэн хуультай тохирох эсэхийг хянах, мөн холбооны болон орон нутгийн эрх баригчдын хооронд үүссэн маргааныг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй.</p> <p>➤ Дээд шүүх</p> <p>Иргэний, эрүүгийн хэргийг шүүн таслах хуулийн дээд байгууллага бөгөөд 20 шүүгчийг Ерөнхийлөгч санал болгосноор Холбооны зөвлөл насаар нь томилно.</p> <p>➤ Хөндлөнгийн шүүх</p> <p>Эдийн засгийн маргаан, тухайлбал, гэрээний маргаан болон доод шатны шүүхийн шийдвэрийг шүүх үүрэгтэй ба 70 гишүүнээс бүрдэнэ. Хэргийг тангарагтнууд бус шүүгчид шийдвэрлэнэ.</p>

¹¹⁴Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 274 дэх тал.

10. ЭНЭТХЭГ

Албан ёсны нэр:	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
Хүн ам:	1,03 тэрбум
Нийслэл:	Дели
Нутаг дэвсгэр:	3,287,585 км ²
Тусгаар тогтносон он:	1947
Үндсэн хууль баталсан он:	1950
Засаг захиргааны нэгж:	28 муж улс, 7 холбоот муж
Харьяа газар нутаг:	Байхгүй
Эрх зүйн бүл:	Англи-Саксоны ¹¹⁵

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
<p>Парламент</p> <p>Хоёр танхимтай. Ардын танхим нь илүү эрх мэдэлтэй, санхүүгийн хууль тогтоомжийг батална. Харин хуулийн төслийг хоёр танхимд хэлэлцдэг.</p> <p>➤ Төрийн буюу Дээд танхим</p> <p>245 гишүүдтэй ба тэдний 233 нь орон нутгийн ассамблей буюу мужийн хууль тогтоох байгууллагууд шууд бус сонгуулиар сонгодог. Бусад 12 нь Ерөнхийлөгчийн санал болгосон хүндэт иргэдээс сонгоно. Гишүүд нь 6 жилийн хугацаатай сонгогдох ба 2 жил тутам тэдний 1/3 хувь нь солигддог.</p> <p>➤ Ардын буюу Доод танхим</p> <p>545 гишүүдтэй, тэдний 543 нь бүх нийтийн санал хуралтаар сонгодох ба үлдсэн 2 гишүүнийг Англи-Энэтхэгийн нийгэмлэгээс Ерөнхийлөгч томилно. Гишүүд 5 жилийн хугацаатай томилогдоно.</p> <p>Орон нутгийн засаг захиргаа</p> <ul style="list-style-type: none"> 28 муж улс, 7 нутаг дэвсгэрийн нэгжүүдэд хуваагдана. Мужийн захирагч сайд нь мужийн хууль тогтоох байгууллагад ажлаа хариуцна. Мужийн захирагчдыг Ерөнхийлөгч томилно. 	<p>Ерөнхийлөгч</p> <p>Орон нутгийн хууль тогтоох байгууллагууд, Парламентын хоёр танхимын гишүүдээр батламжуулсны эцэст 5 жилийн хугацаатай сонгогддог. Тэрээр төрийн тэргүүн, үндэсний эв нэгдлийн билэг тэмдэг байна.</p> <p>➤ Дэд Ерөнхийлөгч</p> <p>5 жилийн хугацаатай сонгогдох ба бүрэн эрхийх нь хугацаа Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаанаас шууд хамаардаг. Тэрээр Дээд танхимын дарга болно.</p> <p>Ерөнхий сайд</p> <p>Хууль тогтоох байгууллагын сонгуулийн дараа Доод танхимыг бүрдүүлж буй олонхын нам бүлгийн даргыг Ерөнхийлөгч Засгийн газрын тэргүүнээр сонгодог. Ерөнхий сайд нь Сайд нарын зөвлөлийн шийдвэрийг Ерөнхийлөгчид дамжуулах үүрэгтэй.</p> <p>➤ Сайд нарын зөвлөл</p> <p>Ерөнхий сайдын санал болгосны дагуу Ардын танхимын гишүүдийн дэмжлэгтэйгээр Ерөнхийлөгч томилдог ба төрийн сайдууд болон дэд сайдуудыг парламент баталдаг.</p>	<p>Дээд шүүх</p> <p>Иргэний, эрүүгийн гэмт хэрэг, Үндсэн хуультай холбогдох хэргийг шүүн таслах дээд байгууллага. Ерөнхий шүүгчийн хамт нийт 26 шүүгчдээс бүрдэх ба Ерөнхий сайдын санал болгосны дагуу Ерөнхийлөгч тэднийг бүх насаар нь томилдог. Шүүх засаглал нь хоёроос дээш мужийн засаг захиргааны хооронд гарсан хэргүүдийг шийдвэрлэх зорилгоор мужуудын дээд шүүхийн хоорондох иргэний болон эрүүгийн гэмт хэргийг шилжүүлэх эсвэл дараагийн шатны шүүх ажиллагааг гүйцэтгэнэ. Нийт 18 шүүхийн шүүгчид нь нэгээс илүү мужийг хариуцан ажиллах бөгөөд ерөнхий шүүгчийг Энэтхэгийн Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, мужийн захирагчийн зөвшөөрөл, зөвлөмжийн дагуу тус улсын Ерөнхийлөгч томилдог. Олон тооны танхимын шүүгчид нь нэг шүүхээс нөгөөрүү шилжиж байдаг бөгөөд шүүгчид 62 насандаа тэтгэвэртээ гардаг.</p> <p>➤ Дүүргийн шүүх</p> <p>Шүүгчдийг мужийн Дээд шүүхийн зөвлөмжөөр тухайн мужийн захирагч томилдог. Дүүрэг бүрд иргэний хэргийг шүүн таслах шүүгчид байдаг.</p>

¹¹⁵Дэлхийн улс орнуудын парламент. УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргасан. УБ., 2010 он. 235 дахь тал.

11. КАНАД

Албан ёсны нэр:	Канад
Хүн ам:	31.6 сая
Нийслэл:	Оттава
Нутаг дэвсгэр:	9,984,670 км ²
Тусгаар тогтносон он:	1867
Үндсэн хууль баталсан он:	1867
Засаг захиргааны нэгж:	10 муж, 3 харьяат муж
Харьяа газар нутаг:	Байхгүй
Эрх зүйн бүл:	Англи-Саксоны ¹¹⁶

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
<p>Парламент</p> <p>Хоёр танхимтай. Хуулийн төсөл нь хоёр танхимаар хэлэлцэнэ. Сенат нь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хэрэгсэхгүй болгох, хуулийн төслийг Нийтийн танхимд дахин хэлэлцүүлэхээр буцаах эрхтэй.</p> <p>➤ Сенат</p> <p>105 сенатыг 75 нас хүртэл нь Амбан захирагч томилно. Сенат нь Засгийн газрын үйл ажиллагаа, бодлогод анхаарах үүрэгтэй.</p> <p>➤ Нийтийн танхим</p> <p>Бүх нийтийн сонгуулиар 5 жилийн хугацаатай сонгогдсон 301 гишүүдтэй. Хэрэв Засгийн газар ялалт байгуулж чадаагүй, эсвэл огцровол Ерөнхий сайд Амбан захирагчаас Засгийн газрыг тараах хүсэлтэ гаргана. Хууль тогтоох засаглалын гол эрхийг эдлэх ба Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй.</p> <p>Орон нутгийн засаг захиргаа</p> <p>10 бие даасан муж, 3 харьяат мужуудад хуваагдах ба бие даасан муж бүрт хууль тогтоох чуулгантай. Хатан хааныг цэргийн захирагчид төлөөлөн удирдана.</p>	<p>Эзэн хаан</p> <p>Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын хаан/хатан хаан байх ба Хамтын нөхөрлөлийн орнуудын эрхэм дээдэс, төрийн тэргүүн, эв нэгдлийн билэг тэмдэг байна.</p> <p>➤ Амбан захирагчийг</p> <p>Эзэн хаан таваас доошгүй жил томилно. Тэрээр Эзэн хааныг төлөөлөн ажиллах үүрэгтэй. Ерөнхий сайдыг томилж, Парламентыг зарлан хуралдуулах, тараах эрхтэй.</p> <p>Ерөнхий сайд</p> <p>Засгийн газрын тэргүүн ба Нийтийн танхимд олонхын суудал авсан намын тэргүүн байна. Нууцын зөвлөл</p> <p>Эзэн хааны зөвлөлдөх зөвлөл ба гишүүдийг нь Ерөнхий сайдын зөвлөснөөр Амбан захирагч томилно.</p> <p>➤ Сайд нарын танхим</p> <p>Ерөнхий сайд муж бүрээс 1 сайдыг гишүүнээр нь томилно. Сайдуд нь Нийтийн танхим, Нууцын зөвлөлийн гишүүд байна.</p>	<p>Дээд шүүх</p> <p>Иргэний ба эрүүгийн, Үндсэн хуулийн бусад хэргүүдийг шүүн таслах шүүх засаглалын хамгийн дээд байгууллага ба шүүгчдийг Ерөнхий сайд дэвшүүлж, Амбан захирагч бүх насаар нь томилно. Дээд шүүхийн ерөнхий шүүгч 75 нас хүртлээ албан тушаал хаших эрхтэй.</p> <p>➤ Холбооны шүүхэд орчин үеийн холбооны шүүх засаглалын бүхий л асуудал хамрагддаг ба албан хаагчид нь ихэвчлэн Канадын иргэд, үндэстэн байна. Хууль эрх зүйн шүүх нь бүх төрлийн эрүүгийн хэргийг шүүн таслах эрхтэй.</p> <p>➤ Мужийн шүүх</p> <p>Муж бүр өөрийн өвөрмөц онцлогт тохирсон шүүхийн тогтолцоотой. Мужийн эрх мэдэл бүхий дээд шүүх, давж заалдах шүүхтэй ба шүүгчдийг холбооны шүүхээс томилно.</p> <p>➤ Татварын шүүх</p> <p>Канадын холбооны шүүхийн дэд хэсэг бөгөөд үндэсний болоод холбооны татварын хууль цааз, дүрэм журмыг ноцтой зөрчсөн, холбогдох хэргүүдийг шүүн таслах, хянах үүрэгтэй.</p>

¹¹⁶Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 227 дахь тал.

12. АВСТРАЛИ

Албан ёсны нэр:	Австралийн Хамтын Нөхөрлөлийн Улс
Хүн ам:	19,3 сая
Нийслэл:	Канберра
Нутаг дэвсгэр:	7,617,930 км ²
Тусгаар тогтносон он:	1901.01.01
Үндсэн хууль баталсан он:	1900.07.09
Засаг захиргааны нэгж:	6 муж улс, 2 харьяат газар
Харьяа газар нутаг:	Аштор Картиерийн арал, Христас арал, Кокосын арал, Шүрэн дайлан арал, Хейрд арал, МакДоналдын арал, Норфолкын арал
Эрх зүйн бүл:	Англи-Саксоны ¹¹⁷

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ ЗАСАГЛАЛ	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
<p>Конгресс</p> <p>2 танхимтай.</p> <p>➤ Сенат</p> <p>Нийт 76 сенатортой ба мужийн тойргуудаас 6 жилийн хугацаатай сонгогдоно. Тэдний хагас нь 3 жил тутамд шинээр сонгогдоно.</p> <p>➤ Төлөөлөгчдийн танхим</p> <p>Сенатын гишүүдийг 2 дахин нэмсэнтэй тэнцэх тооны гишүүдтэй. Танхим нь 150 суудалтай ба муж, харьяа нутаг дэвсгэрийн хуваарилалтаас тус бүр 5 гишүүн сонгогдоно. Танхимын гишүүд нь 3 жилийн хугацаатай бүх ард түмний сонгуулиар сонгогдоно.</p> <p>Орон нутгийн засаг захиргааны</p> <ul style="list-style-type: none"> 6 муж улс, 2 харьяат газар муж улсуудын парламент нь хоёр танхимтай 	<p>Эзэн хаан</p> <p>Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын хаан/хатан хаан байх ба Хамтын нөхөрлөлийн орнуудын эрхэм дээдэс, төрийн тэргүүн, эв нэгдлийн билэг тэмдэг.</p> <p>➤ Амбан захирагч</p> <p>Ерөнхий сайдтай зөвшөлцөн Эзэн хаан томилно. Тэрээр Парламентыг зарлан хуралдуулах, тараах эрхтэй. Парламентаар зөвшөөрөгдсөн байна. Тэрээр өөрийн хүсэлтээр огцрох, эсвэл Хааны зарлигаар буух хүртлээ тус албыг хашина.</p> <p>Ерөнхий сайд</p> <p>Төлөөлөгчдийн танхимд олонх болсон нам эвслийн тэргүүн байх ба Сайд нарын танхимыг даргална.</p> <p>➤ Холбооны гүйцэтгэх зөвлөлд</p> <p>Бүх сайд нар орох ба Амбан захирагч нь зөвлөх үүрэгтэй. Сайд нарын танхимын Гишүүд 16 сайдыг тус улсын Парламентын гишүүдээс Ерөнхий сайдын зөвлөснөөр Амбан захирагч томилно.</p>	<p>Дээд шүүх</p> <p>Тус улсын шүүх засаглалын эрх бүхий дээд байгууллага, иргэн, эрүүгийн гэмт хэргийг шүүн таслахын зэрэгцээ муж улсуудын хоорондын маргаантай асуудлууд, олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн зарчим, журам болон Үндсэн хуулийн холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилтэнд хяналт тавина. Шүүхийн гишүүд болох 7 шүүгчдийг Амбан захирагч 70 нас хүртэл нь томилдог.</p> <p>➤ Холбооны шүүх</p> <p>Иргэн, эрүүгийн хэргийн хууль тогтоомж, үндэстэн хоорондын маргаан, дамлуурал, хамтын ажиллагаатай холбогдсон элдэв маргаан зөрчилд холбогдох хэргүүдийг шүүн тасалж хэлэлцэнэ. 45 Шүүгчдийг Амбан захирагч 70 нас хүртэл нь томилдог.</p> <p>➤ Гэр бүлийн шүүх</p> <p>Гэр бүлийн зөрчил, цуцлалт, хүүхэд асран хүмүүжүүлэх тухай хуульд хамраах хэргүүдийг шийдвэрлэнэ. Шүүгчдийн Амбан захирагч томилно.</p>

¹¹⁷Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 227 дахь тал.

13. ИСПАНИ

Албан ёсны нэр:	Испанийн Вант Улс
Хүн ам:	39.9 сая
Нийслэл:	Мадрид
Нутаг дэвсгэр:	504,782 км ²
Тусгаар тогтносон он:	1492
Үндсэн хууль баталсан он:	1978
Засаг захиргааны нэгж:	19 бие даасан муж улс
Харьяа газар нутаг:	Исла Карифан, Пеньон-де-Алусемас, Пеньон де Велез,
де ла Гомера	
Эрх зүйн бүл:	Ром-Германы ¹¹⁸

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
<p>Парламент</p> <p>Хоёр танхимтай.</p> <p>➤ Сенат</p> <p>Мужуудаас сонгогдсон 208 гишүүнтэй, тэдний 51 нь автономит мужийн парламентаас шууд сонгогддог. Бүрэн эрхийн хугацаа 4 жил. Сенатын гишүүд хуулийн төсөл санаачлах эрхгүй ч хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй.</p> <p>➤ Төлөөлөгчийн танхим</p> <p>Пропорциональ системээр бүх нийтийн сонгуулиар сонгогдсон 350 гишүүнтэй. Бүрэн эрхийн хугацаа 4 жил. Танхим нь хууль тогтоомж санаачлах эрхтэй.</p> <p>Мужийн засаг захиргаа</p> <ul style="list-style-type: none"> Бие даасан 19 муж улстай. Муж улс бүр Ерөнхийлөгчөө сонгодог ба нэг танхимтай Парламенттай. Муж улс бүр Дээд шүүхтэй. 	<p>Эзэн хаан</p> <p>Тэрээр угсаа залгамжлагч ба төрийн тэргүүн, эв нэгдлийн билэгдэл, зэвсэгт хүний ерөнхий командлагч байна. Тэрээр Төлөөлөгчдийн танхимын зөвлөснөөр Засгийн газрын ерөнхийлөгч буюу тэргүүнийг, Засгийн газрын ерөнхийлөгчийн зөвлөснөөр дэд Ерөнхийлөгчийг томилно. Дэд ерөнхийлөгч нь Засгийн газрын тэргүүний орлогч юм. Мөн хууль тогтоох засаглалыг дэмжих, тараах эрхтэй.</p> <p>➤ Төрийн зөвлөл</p> <p>Төрийн өндөр албан тушаалтнууд, зэвсэгт хүчин, төрийн албаны тэргүүлэгч ажилтнуудыг багтаасан зөвлөлдөх дээд байгууллага юм. Ерөнхийлөгчийг нь Сайд нарын зөвлөлөөс томилно.</p> <p>Засгийн газрын Ерөнхийлөгч</p> <p>Засгийн газрын тэргүүн нь Парламентад олонхын суудалтай намын тэргүүн байна. Эзэн хаан түүнийг Төлөөлөгчдийн танхимд санал болгосноор сонгох ба хоёр дэд Ерөнхийлөгчийг дэвшүүлэн томилдог байна.</p> <p>➤ Сайд нарын зөвлөл</p> <p>Ерөнхий сайд, түүний дэд сайдууд тэргүүлэх бөгөөд Засгийн газрын бодлогыг тодорхойлно.</p>	<p>Дээд шүүх</p> <p>Шүүх засаглалын дээд байгууллага ба иргэн, эрүү, захиргаа, нийгмийн болон цэргийн танхимуудад хуваагдана. Нийт 95 шүүгчдийг Дээд шүүхийн Ерөнхийлөгч удирдана. Тэдний бүрэн эрхийг Шүүхийн зөвлөлийн 20 гишүүн (зөвлөлийн гишүүдийн 8-ыг нь парламент, 12-ыг нь шүүгчдээс томилдог)-ийг нэр дэвшүүлж, Хаан томилно.</p> <p>➤ Үндсэн хуулийн шүүх</p> <p>Мужийн асуудалтай холбоотой хуулийн төслийг Зөвлөлөөр батлуулна. Зөвлөл санхүүтэй холбоотой хуулийн төсөлд хяналт тавьж батална. Шүүхийн 12 шүүгчдийг Засгийн газар, Шүүхийн зөвлөл, Парламентаас 9 жилийн хугацаатайгаар томилно.</p> <p>➤ Анхан шатны шүүх</p> <p>Муж улс бүр Дээд шүүх, мужийн шүүх, анхан шатны шүүх, хотын шүүхтэй. Нэгдсэн болон бие даан үйл ажиллагаа явуулдаг шүүхүүд нь хууль бусаар мөнгө угаалт, хар тамхи, мансууруулах бодис худалдаалах, алан хядлагатай холбоотой хэргүүдийг шүүн таслах, хянан шийдвэрлэх эрхтэй.</p>

¹¹⁸Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 240 дэх тал.

14. ӨМНӨД СОЛОНГОС

Албан ёсны нэр:	Бүгд Найрамдах Солонгос Улс
Хүн ам:	47,1 сая
Нийслэл:	Дели
Нутаг дэвсгэр:	98,480 км ²
Тусгаар тогтносон он:	1948
Үндсэн хууль баталсан он:	1948
Засаг захиргааны нэгж:	9 муж, 7 хот
Харьяа газар нутаг:	Байхгүй
Эрх зүйн бүл:	Ром-Германы эрх зүйн бүлд хамаарах боловч хууль тогтоомжид нь Америкийн эрх зүйгээс нэлээд зүйлийг авсан. ¹¹⁹

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
<p>Парламент</p> <p>Нэг танхимтай.</p> <p>Үндэсний Ассамблей</p> <p>273 гишүүдтэй. Тэдний 227 нь бүх нийтийн сонгуулиар, 46 нь сонгуулийн үр дүнгээс хамаарч улс төрийн намуудын нэрсийн жагсаалтаар сонгогдоно. Бүрэн эрхийн хугацаа 4 жил байна.</p> <p>Орон нутгийн засаг захиргаа</p> <p>9 мужийг захирагчид удирдана.</p>	<p>Ерөнхийлөгч</p> <p>Бүх ард түмний сонгуулиар 5 жилийн хугацаатайгаар нэг удаа сонгогдоно. Тэрээр төрийн тэргүүн, хууль тогтоох байгууллагын тэргүүлэгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн албыг хашина.</p> <p>➤ Ерөнхий сайд</p> <p>Ерөнхийлөгч томилох ба Засгийн газрыг тэргүүлнэ.</p> <p>➤ Төрийн зөвлөл</p> <p>Ерөнхий сайд санал болгосноор Ерөнхийлөгчийн томилсон 20 гишүүдээс бүрдэнэ. Тэд засгийн газрын үйл ажиллагааг хянана.</p>	<p>Үндсэн хуулийн шүүх</p> <p>Нийт 9 шүүгчтэй, тэдний гурвыг нь Ерөнхийлөгч, гурвыг нь Үндэсний ассамблей, бусад гурвыг нь Шүүхийн дарга тус тус томилно.</p> <p>➤ Дээд шүүх</p> <p>Хууль тогтоох дээд байгууллага бөгөөд гишүүдийг нь 6 жилийн хугацаатай Үндэсний ассамблейн зөвшөөрснөөр Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг дахин томилж болно.</p> <p>➤ Ерөнхий ба Доод шатны шүүх</p> <p>Шүүгч, ерөнхий шүүгч нар Дээд шүүхийн бага хурлаар батлагдан 10 жилийн хугацаатай томилогдоно.</p>

¹¹⁹Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 411 дэх тал.

15. МЕКСИК

Албан ёсны нэр:	Мексикийн Нэгдсэн Улс
Хүн ам:	100,4 сая
Нийслэл:	Мексик
Нутаг дэвсгэр:	1,972,550 км ²
Тусгаар тогтносон он:	1836
Үндсэн хууль баталсан он:	1917
Засаг захиргааны нэгж:	31 муж улс, 1 холбооны дүүрэг
Харьяа газар нутаг:	Байхгүй
Эрх зүйн бүл:	Ром-Германы ¹²⁰

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
<p>Конгресс</p> <p>Хоёр танхимтай.</p> <p>➤ Сенат</p> <p>Нийт 128 гишүүнтэй, тэдгээрийн 96 нь бүх нийтийн сонгуулиар, бусад 32 гишүүнийг нам бүрээс нэр дэвшүүлэн сонгодог. Гишүүд дахин сонгогдохгүйгээр 6 жилийн хугацаатай ажиллана. Танхим нь гадаад бодлогыг чиглүүлэх, олон улсын гэрээ хэлэлцээрийг батлах, ерөнхийлөгчийг томилох эрхтэй.</p> <p>➤ Төлөөлөгчдийн танхим</p> <p>500 гишүүнтэй, тэдний 300 нь бүх нийтийн сонгуулиар, 200 гишүүнийг нь сонгуулийн 5 мужаас нам бүрээс нэр дэвшүүлэн сонгоно. Гишүүд нь дахин сонгогдохгүйгээр 3 жилийн хугацаатай ажиллана.</p> <p>Орон нутгийн засаг захиргаа</p> <p>31 муж улсыг орон нутгийн сонгуулиар сонгогдсон захирагчид удирдана.</p>	<p>Ерөнхийлөгч</p> <p>Бүх нийтийн сонгуулиар 6 жилийн хугацаатай сонгоно. Дахин сонгогдохгүй. Тэрээр төрийн тэргүүн бөгөөд Засгийн газраа толгойлно, зэвсэгт хүчний ерөнхий командлагч ба Конгресст хууль тогтоомж танилцуулах, хуулийн төсөлд хориг тавих, зарлиг тогтоол гаргах эрхтэй.</p> <p>➤ Сайд нарын танхим</p> <p>Ерөнхийлөгч томилж, Сенат батална. Танхим нь засгийн газар, түүний бодлогод хяналт тавина.</p> <p>➤ Гүйцэтгэх агентлаг</p> <p>Ерөнхий захирагчийг Конгрессын зөвшөөрлөөр Ерөнхийлөгч томилно.</p>	<p>Дээд шүүх</p> <p>Холбооны болон муж улсуудын шүүхийг хянах шүүх засаглалын дээд байгууллага. 11 шүүгчийг Сенаттай зөвшилцснөөр Ерөнхийлөгч томилох, огцруулах эрхтэй. Шүүгчид 65 нас хүртлээ ажиллана.</p> <p>➤ Холбооны улсын шүүх</p> <p>Иргэн, онц ноцтой эрүүгийн хэргийг шүүх ба эрүүгийн хэрэг дээр гэм буруутанг нь тогтоосон бол тангарагтны шүүгчидгүйгээр шүүнэ.</p> <p>➤ Муж улсын шүүх</p> <p>Орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулах ба Шүүхийн дээд зөвлөлийн шүүгчдийг хууль тогтоох засаглалын зөвшөөрснөөр захирагчид томилно.</p>

¹²⁰Дэлхийн улс орнуудын парламент. УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргасан. УБ., 2010 он. 298 дахь тал.

16. КАТАР

Албан ёсны нэр:	Катар улс
Хүн ам:	575 мянга
Нийслэл:	Доха
Нутаг дэвсгэр:	11,437 км ²
Тусгаар тогтносон он:	1971
Үндсэн хууль баталсан он:	1972
Засаг захиргааны нэгж:	10 муж
Харьяа газар нутаг:	Байхгүй
Эрх зүйн бүл:	Исламын Шариатын эрх зүйд тулгуурладаг. ¹²¹

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ ЗАСАГЛАЛ	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
Парламент (Majlis al-Shura) Нэг танхимтай Зөвлөх зөвлөл Нийт 35 гишүүнтэй. Бүрэн эрхийн хугацаа 3 жил. Зөвлөлийн гишүүдийг Эмир томилдог. Хууль хянах, зөвлөх, Засгийн газарт хяналт тавих үүрэгтэй. Орон нутгийн засаг захиргаа 10 мужтай.	Эмир Угсаа залгамжилан төрийн эрхийг барина. Гүйцэтгэх эрх мэдлийг дангаар хэрэгжүүлэгч, зэвсэгт хүчний ерөнхий командлагч, зарлиг гаргах, төрийн албан хаагчид болон цэргийн тушаалтнуудыг томилох, огцруулах эрхтэй. Эмир нь хууль тогтоох байгууллагаа тараах бүрэн эрхтэй. ➤ Ерөнхий сайд Эмир томилох бөгөөд ихэвчлэн Эзэн хааны гэр бүлийн аль нэг гишүүнийг томилно. Засгийн газрын тэргүүн тэрээр засгийн газрын хэрэгжүүлж буй хөтөлбөр, түүний санхүүжилтийн асуудлыг хянаж ажилладаг. ➤ Сайд нарын зөвлөл Зөвлөлийг гишүүдийг Эмир томилно. Хуулийн төсөл боловсруулах, засгийн газрын үйл ажиллагааг хянах үүрэгтэй.	Дээд шүүх Шүүх байгууллагын дээд шатны шүүхийн шүүгчдийг Хууль зүйн сайд сонгох ба тэдгээр нь улс орныхоо нэр хүндтэй хуулийн сургууль эсвэл Шариатын коллеж төгссөн хуульчид байна. ➤ Эрүүгийн хэргийн шүүх ➤ Эрүүгийн хэргийн доод шатны шүүх ➤ Худалдаа, гэрээний хэргийн шүүх ➤ Хөдөлмөрийн шүүх ➤ Шариатын шүүх ➤ Иргэдийн хувийн асуудлыг хэлэлцэх шүүх

¹²¹Дэлхийн улс орнуудын парламент. УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргасан. УБ., 2010 он. 148 дахь тал.

17. ЛЮКСЕМБУРГ

Албан ёсны нэр:	Люксембургын Их Вант Улс
Хүн ам:	442.000
Нийслэл:	Люксембург
Нутаг дэвсгэр:	2.585 км ²
Тусгаар тогтносон он:	1867
Үндсэн хууль баталсан он:	1868
Засаг захиргааны нэгж:	3 дүүрэг
Харьяа газар нутаг:	Байхгүй
Эрх зүйн бүл:	Ром-Германы ¹²²

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
<p>Парламент</p> <p>(Chamber des Deputes)</p> <p>Нэг танхимтай.</p> <p>Төлөөлөгчдийн танхим</p> <p>Танхимын 60 гишүүнийг сонгуулийн тойргуудаас хувь тэнцүүлэх зарчмаар, бүх нийтийн сонгуулиар 5 жилийн хугацаатай сонгоно. Хуулийн төслийн талаар Төлөөлөгчдийн танхим болон Төрийн зөвлөлийн санал зөрвөл 3 сарын дараа дахин санал хураалтанд оруулах журамтай.</p> <p>Орон нутгийн засаг захиргаа</p> <p>3 дүүрэгтэй.</p>	<p>Их ван</p> <p>Угсаа залгамжилсан Их ван нь төрийн тэргүүн ба Төлөөлөгчдийн танхимыг тараах эрхтэй. Засгийн газартай хамт төрийн эрхийг барина.</p> <p>Ерөнхий сайд</p> <p>Парламентад олонх болсон нам, эвслийн тэргүүнийг Ерөнхий сайдад нэр дэвшүүлж, Их ван томилно. Ерөнхий сайд нь засгийн газрын тэргүүн бөгөөд Төлөөлөгчдийн танхимд тайлагнана.</p> <p>➤ Шадар сайд</p> <p>Их ван томилно.</p> <p>➤ Сайд нарын зөвлөл</p> <p>Зөвлөлийн гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Их ван томилно.</p> <p>➤ Төрийн Зөвлөл</p> <p>21 гишүүнийг Ерөнхий сайдын зөвлөснөөр Их ван бүх насаар нь томилно. Зөвлөл нь хуулийн төслийг Төлөөлөгчдийн танхимд танилцуулахаас өмнө хянан хэлэлцэж, саналаа илэрхийлнэ.</p>	<p>Шударга ёсны дээд шүүх</p> <p>Шүүхийн шийдвэрийг хянан хэлэлцэх, давж заалдах дээд байгууллага. 16 шүүгчдийг тус шүүхийн нь зөвлөсний дагуу Их ван бүх насаар нь томилно.</p> <p>➤ Дүүргийн шүүх</p> <p>➤ Энх тайвны шүүх</p>

¹²²Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 240 дэх тал.

18. СИНГАПУР

Албан ёсны нэр:	Бүгд Найрамдах Сингапур Улс
Хүн ам:	4.1 сая
Нийслэл:	Сингапур
Нутаг дэвсгэр:	611 км ²
Тусгаар тогтносон он:	1965
Үндсэн хууль баталсан он:	1959
Засаг захиргааны нэгж:	Байхгүй
Харьяа газар нутаг:	Байхгүй
Эрх зүйн бүл:	Англи-Саксоны ¹²³

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
Парламент Нэг танхимтай. Бүх ард түмний сонгуулиар 5 жилийн хугацаатай сонгогдсон 84 гишүүдээс бүрдэнэ.	Ерөнхийлөгч Бүх ард түмний сонгуулиар 6 жилийн хугацаатайгаар сонгогдоно. ➤ Ерөнхий сайд Парламентад олонхын суудал авсан нам, эвслийн тэргүүнийг Ерөнхий сайдад нэр дэвшүүлж, Ерөнхийлөгч томилно. ➤ Сайд нарын танхим Парламентын гишүүдээс бүрдэх ба Ерөнхий сайдын зөвлөсний дагуу Ерөнхийлөгч томилно.	Дээд шүүх Давж заалдах шүүх ба Танхимын шүүх гэж хоёр хуваагдана. Ерөнхий шүүгч болон бусад шүүгчдийг Ерөнхийлөгч 65 нас хүртэл нь томилдог. ➤ Давж заалдах шүүх Танхимын шүүхийн иргэний, эрүүгийн хэргүүдийг хянан үзэх үүрэгтэй. ➤ Танхимын шүүх Онц ноцтой гэмт хэрэг, иргэний хэргийг шүүн таслах бөгөөд анхан шатны шүүхийн хэргийг хянаана. ➤ Дүүргийн шүүх Шүүгчдийн зөвлөлийн шүүх

¹²³Дэлхийн улс орнуудын парламент. УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргасан. УБ., 2010 он. 191 дэх тал.

19. БРУНЕЙ

Албан ёсны нэр:	Брунейн Вант улс (Дарусалим)
Хүн ам:	335.000
Нийслэл:	Бандар-Сери-Бегаван
Нутаг дэвсгэр:	5.770 км ²
Тусгаар тогтносон он:	1984
Үндсэн хууль баталсан он:	1959
Засаг захиргааны нэгж:	4 дүүрэг
Харьяа газар нутаг:	Байхгүй
Эрх зүйн бүл:	Холимог (Англи-Исламын шариатын эрх зүйн зэрэгцээ системд суурилсан) ¹²⁴

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ ЗАСАГЛАЛ	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
Парламент (Majlis Masyurat) Нэг танхимтай. Нийт 20 гишүүнтэй, тэдгээрийг Султан томилдог. Орон нутгийн засаг захиргаа 4 дүүрэгтэй, дүүрэг болгон захирагчтай.	Султан Угсаа залгамжлан төрийн эрх барих эрхтэй ба төрийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч, шашны удирдагч, Ерөнхий сайд байна. Хуультай адил үйлчлэх зарлиг гаргах эрхтэй. ➤ Нууцын Зөвлөл Гишүүдийг Султан томилно. Үндсэн хууль болон төрийн цол, хэргэмийн талаарх асуудал, маргааныг шийдвэрлэхэд зөвлөгөө өгөх үүрэгтэй. ➤ Эрх шилжүүлэх зөвлөл Гишүүдийг Султан томилно. Хаан ширээнд суух дараагийн хүнийг тодорхойлох үүрэгтэй. ➤ Шашны зөвлөл Гишүүдийг Султан томилох ба Исламын эрх зүй, шариатын эрх зүйн асуудлаар Султанд зөвлөгөө өгөх эрхтэй.	Дээд шүүх Дээд шүүх нь дотроо иргэн, эрүүгийн хэргийн дээд шүүх болон хуулийн агуулга тайлбарлах гэсэн чиглэлүүдэд хуваагддаг. Шүүгчид нь Британийн хамтын нөхөрлөлийн шүүгчид байдаг. Иргэний хэргийн эцсийн шийдвэрийг (үүнд эрүүгийн хэрэг орохгүй) Лондон дахь Нууцын Зөвлөл гаргаж болно. ➤ Дунд шатны шүүх Шүүгчдийг Султан томилно. Хөнгөн хэргүүдийг шийдвэрлэнэ. ➤ Исламын шүүх Исламын шашинт иргэдийн үйлдсэн гэмт үйлдлийг зохицуулах зорилготой.

¹²⁴Дэлхийн улс орнуудын парламент. УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргасан. УБ., 2010 он. 106 дахь тал.

20. КУВЕЙТ

Албан ёсны нэр:	Кувейт улс
Хүн ам:	2 сая
Нийслэл:	Кувейт
Нутаг дэвсгэр:	17.819 км ²
Тусгаар тогтносон он:	1961
Үндсэн хууль баталсан он:	1962
Засаг захиргааны нэгж:	5 муж
Харьяа газар нутаг:	Байхгүй
Эрх зүйн бүл:	Исламын Шариатын эрх зүйд тулгуурладаг. ¹²⁵

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ ЗАСАГЛАЛ	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
<p>Парламент</p> <p>(Majlis al-Umma)</p> <p>Нэг танхимтай.</p> <p>50 гишүүнтэй. Тэдгээрийг 25 тойрог тус бүрээс 2 төлөөллөөр сонгоно. Бүрэн эрхийн хугацаа 4 жил. Хууль санаачлах, тогтоол гаргах, засгийн газрын үйл ажиллагааг хянах үүрэгтэй.</p> <p>Орон нутгийн засаг захиргаа</p> <p>5 мужийн захирагч нарыг Эмир томилно.</p>	<p>Эмир</p> <p>Угсаа залгамжлан хаан ширээнд суудаг. Төрийн тэргүүн, зэвсэгт хүчний командлагч тэрээр хууль санаачлах, тогтоол гаргах, иргэний, цэргийн болон дипломат алба тушаалтнуудыг томилох, огцруулах ба ял хөнгөлөх, уучлал үзүүлэх эрхтэй.</p> <p>➤ Ерөнхий сайд</p> <p>Уламжлалын дагуу хунтайж Ерөнхий сайд болдог. Ерөнхий сайдыг Эмир томилно. Тэрээр Засгийн газрыг тэргүүлнэ.</p> <p>➤ Сайд нарын зөвлөл</p> <p>16 гишүүнтэй. Эмир баталж, Ерөнхий сайд томилно.</p>	<p>Үндсэн хуулийн Зөвлөл</p> <p>Сонгуулийн маргааныг шийдвэрлэх, хууль тогтоомж Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавьдаг. 6 гишүүнтэй, тэдний 5-ыг нь Шүүхийн зөвлөл, 1-ийг Эмир томилно.</p> <p>➤ Кассацийн шүүх</p> <p>Давж заалдах дээд шатны шүүх. Гишүүдийг нь Эмир томилно. 65 нас хүртлээ албан үүргээ гүйцэтгэнэ.</p> <p>➤ Давж заалдах шатны шүүх</p> <p>Доод шатны шүүхийн шийдвэрийг хянах үүрэгтэй. Шүүгчдийг Эмир томилно. 65 нас хүртлээ албан үүргээ гүйцэтгэнэ.</p> <p>➤ Анхан шатны шүүх</p> <p>Иргэн, эрүүгийн хэргийг шүүнэ. Шүүгчдийг Эмир томилно. 65 нас хүртлээ албан үүргээ гүйцэтгэнэ.</p>

¹²⁵Дэлхийн улс орнуудын парламент. УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргасан. УБ., 2010 он. 154 дэх тал.

21. НОРВЕГИ

Албан ёсны нэр:	Норвегийн Вант Улс
Хүн ам:	4.5 сая
Нийслэл:	Осло
Нутаг дэвсгэр:	324.219 км ²
Тусгаар тогтносон он:	1905
Үндсэн хууль баталсан он:	1814
Засаг захиргааны нэгж:	19 муж, 19 фюльке (губерний)
Харьяа газар нутаг:	Буветийн арал, Яан Маеэн, Свалвард
Эрх зүйн бүл:	Скандинавын ¹²⁶

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
<p>Парламент (Storting)</p> <p>Нэг танхимтай. Бүх нийтийн сонгуулиар сонгогдсон 169 гишүүнээс бүрдэнэ. Бүрэн эрхийн хугацаа 4 жил. Парламентын сонгууль нэгдсэн байдлаар явагдах ба сонгогдсон гишүүдийг байнгын болон ерөнхий танхимд хуваана. Хуулийн төслийг хоёр танхимаар тус тусдаа хэлэлцэж, гишүүдийн олонхын саналаар батална. Төслийн талаар саналын зөрүүтэй бол хамтарсан хуралдаанаар 2/3-ын саналаар батлана.</p> <p>Орон нутгийн засаг захиргаа</p> <p>19 мужийг сонгогдсон зөвлөл захирна.</p>	<p>Эзэн хаан</p> <p>Угсаа залгамжлагч эзэн хаан нь төрийн тэргүүн, хуурай замын болон усан цэргийн ерөнхий командлагч, Норвегийн сүм, хийдүүдийн тэргүүн байна. Парламентын онцгой чуулганыг зарлан хуралдуулах, нээх, хуульд хориг тавих эрхтэй.</p> <p>➤ Ерөнхий сайд</p> <p>Парламентад олонх болсон нам, эвслийн тэргүүнийг Ерөнхий сайдад нэр дэвшүүлж, Парламентын зөвшөөрсний дагуу Эзэн хаан томилно. Тэрээр Засгийн газрыг тэргүүлнэ.</p> <p>➤ Төрийн зөвлөл</p> <p>Гишүүдийг Парламентын зөвшөөрсний дагуу Эзэн хаан томилно.</p>	<p>Дээд шүүх</p> <p>(Hoyesterett)</p> <p>Шүүхийн шийдвэр биелүүлэх, хянан хэлэлцэх шүүх засаглалын дээд байгууллага. Дээд шүүхийн Ерөнхийлөгч болон 17 шүүгчийг Хууль зүйн яам нэр дэвшүүлж, Эзэн хаан томилно.</p> <p>➤ Давж заалдах шатны шүүх</p> <p>➤ Хотын болон аймгийн шүүх</p>

¹²⁶Д. Баярсайхан. Эрх зүйн онол. 2006 он.

22. АРАБЫН НЭГДСЭН ЭМИРАТ УЛС

Албан ёсны нэр:	Арабын Нэгдсэн Эмират Улс
Хүн ам:	2.7 сая
Нийслэл:	Абу-Даби
Нутаг дэвсгэр:	82.880 км ²
Тусгаар тогтносон он:	1971
Үндсэн хууль баталсан он:	1871
Засаг захиргааны нэгж:	7 эмират улс
Харьяа газар нутаг:	Байхгүй
Эрх зүйн бүл:	Исламын Шариатын эрх зүйд тулгуурладаг. ¹²⁷

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ ЗАСАГЛАЛ	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
Парламент (Majlis al-Ittihad al-Watani) Нэг танхимтай. ➤ Холбооны үндэсний ассамблей Нийт 40 гишүүнтэй. Тэдгээрийн 20-ийг нь Холбооны дээд зөвлөлөөс, 20-ийг нь шууд бусаар сонгодог. Бүрэх эрхийн хугацаа 4 жил. Хуулийн төслийг хэлэлцүүлэн хянах, зөвлөх, санал дэвшүүлэх үүрэгтэй. Хуулийн төсөлд хориг тавих, хуульд нэмэлт, өөрчлөх оруулах эрхгүй. Орон нутгийн засаг захиргаа 7 Эмират улс	Холбооны дээд зөвлөл Төрийн эрх барих дээд байгууллага бөгөөд 7 эмирээс бүрдэнэ. Хууль батлах, өөрсдийн гишүүдээс Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг сонгодог. Жилд 4 удаа хуралддаг. ➤ Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч Холбооны дээд зөвлөлөөс 5 жилийн хугацаатай сонгоно. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, Холбооны дээд зөвлөлийг даргалах ба зэвсэгт хүчнийг удирдана. ➤ Ерөнхий сайд Засгийн газрын тэргүүнийг Ерөнхийлөгч томилно. ➤ Сайд нарын танхим Гишүүдийг Ерөнхий сайд томилно.	Холбооны Дээд шүүх Эмиратуудын хоорондын зөрчил маргаан, эмират болон Холбооны засгийн газар хоорондын маргааныг шийдвэрлэх, хууль тогтоомж Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавьдаг. 5 шүүгчийг Ерөнхийлөгч томилно. ➤ Холбооны доод шатны шүүх Холбооны засгийн газар татагдан орсон иргэний болон худалдааны хэргүүдийг шүүн хэлэлцэнэ. ➤ Орон нутгийн шүүх Абу Даби дахь Холбооны Хууль зүйн яамнаас нэгдсэн удирдлагаар хангана.

¹²⁷Дэлхийн улс орнуудын парламент. УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргасан. УБ., 2010 он. 186 дэх тал.

23. САН-МАРИНО

Албан ёсны нэр:	Бүгд Найрамдах Сан Марино Улс
Хүн ам:	26.900
Нийслэл:	Сан-Марино
Нутаг дэвсгэр:	61.1 км ²
Тусгаар тогтносон он:	301
Үндсэн хууль баталсан он:	1600
Засаг захиргааны нэгж:	9 бие даасан муж
Харьяа газар нутаг:	Байхгүй
Эрх зүйн бүл:	(мэдээлэл олдоогүй)

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
<p>Парламент</p> <p>(Consiglio Grande e Generale)</p> <p>Нэг танхимтай.</p> <p>➤ Дээд ерөнхий зөвлөл</p> <p>60 гишүүдийг сонгуулийн хувь тэнцүүлсэн пропорциональ системээр 5 жилийн хугацаатай сонгоно. Зөвлөл нь хууль тогтоох эрхтэйгээс гадна улсын төсөв батлах, Капитан-регент, Төрийн конгресс, 12-ын зөвлөл, Зөвлөх комисс болон Засгийн газрын холбоог сонгох эрхтэй.</p> <p>Орон нутгийн Засаг захиргаа</p> <p>9 өөртөө засах мужийг орон нутгаас сонгогдсон зөвлөлүүд удирдана.</p>	<p>Капитан-регент</p> <p>Дээд ерөнхий зөвлөлөөс жилд 2 капитан-регентийг томилох бөгөөд Капитан-регент нь төрийн тэргүүний албыг тус бүрдээ хагас жилээр гүйцэтгэдэг. Капитан-регент нь Дээд ерөнхий зөвлөл, Төрийн конгресс, 12-ын зөвлөлийг тэргүүлдэг.</p> <p>➤ Төрийн конгресс</p> <p>Парламентаас сонгогдсон 10 нарийн бичгийн даргаас бүрдэх ба 5 жилийн хугацаатай төрийн сайдын үүргийг гүйцэтгэнэ. Төрийн конгресс нь хууль эрх зүй, бодлогын хэрэгжилт, зорилтуудыг шийдвэрлэх, зохион байгуулах үүрэгтэй. Гадаад болон улс төрийн хэрэг хариуцсан Төрийн нарийн бичгийн дарга нь засгийн газрын тэргүүн байна.</p>	<p>12-ын зөвлөл</p> <p>Шүүх засаглалын дээд байгууллага бөгөөд Дээд ерөнхий зөвлөлийн хууль тогтоох ажиллагаанд шүүх эрх мэдлийг төлөөлөн оролцдог. Хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх зорилготой 15 зөвлөхийг 5 жилийн хугацаатайгаар Парламентаас томилно.</p> <p>➤ Энх тайвны шүүх</p>

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

24. ШВЕЙЦАРЬ

Албан ёсны нэр:	Швейцарийн Холбооны Улс
Хүн ам:	7,2 сая
Нийслэл:	Берн
Нутаг дэвсгэр:	41,290 км ²
Тусгаар тогтносон он:	1291
Үндсэн хууль баталсан он:	1874
Засаг захиргааны нэгж:	26 тойрог
Харьяа газар нутаг:	Байхгүй
Эрх зүйн бүл:	Ром-Германы ¹²⁸

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ ЗАСАГЛАЛ	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
<p>Холбооны Ассамблей</p> <p>Хоёр танхимтай.</p> <p>➤ Төрийн зөвлөл</p> <p>Бүх нийтийн сонгуулиар сонгогдсон 46 гишүүнээс бүрдэнэ. Бүрэн эрхийн хугацаа 4 жил. Тэдний 20 нь "бүтэн" тойргоос тус бүр 2, 6 нь "хагас" тойргоос тус бүр 1 сонгогдоно.</p> <p>➤ Үндэсний зөвлөл</p> <p>Пропорционал системээр 4 жилийн хугацаатайгаар сонгогдсон 200 гишүүнээс бүрдэнэ.</p> <p>Орон нутгийн засаг захиргаа</p> <p>26 тойрог бүр хууль тогтоох байгууллагатай ба тэдгээр нь гүйцэтгэгчдийг томилно.</p>	<p>Холбооны зөвлөл</p> <p>7 гишүүнийг парламентаас 4 жилийн хугацаатай сонгоно. Тэдний 2 нь Христийн ардчиллын нам, 2 нь Социал демократ нам, 2 нь Чөлөөт ардчиллын нам, 1 нь Швейцарийн ардын намаас тус тус сонгогдоно. Холбооны зөвлөлийн гишүүд нь засгийн үйл ажиллагаанд хяналт тавина.</p> <p>➤ Ерөнхийлөгч</p> <p>Ерөнхийлөгчийг жил бүр Холбооны зөвлөлийн гишүүдээс сонгож, Парламентаас баталдаг. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүн ба Холбооны зөвлөлийн үйл ажиллагаанд зохион байгуулах эрхтэй.</p> <p>➤ Дэд ерөнхийлөгч</p> <p>Дэд ерөнхийлөгчийг жил бүр Холбооны зөвлөлийн гишүүдээс сонгож Парламентаас батална. Тэрээр Ерөнхийлөгчийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ түүнийг эзгүйд Ерөнхийлөгчийн үүргийг нь гүйцэтгэнэ.</p>	<p>Холбооны шүүх</p> <p>Иргэн, эрүүгийн хэргийг шүүн хэлэлцэх, шийдвэрлэх үүрэгтэй шүүх засаглалын дээд байгууллага. Холбооны шүүхийн шүүгчдийн 30 нь байнгын, үлдсэн 30 нь байнгын бус гишүүд байна. Шүүгчдийг парламентаас 6 жилийн хугацаатай томилно.</p> <p>➤ Цэргийн шүүх</p> <p>➤ Захиргааны шүүх</p> <p>➤ Тойргийн шүүх</p>

¹²⁸Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 240 дэх тал.

25. САУДЫН АРАБ

Албан ёсны нэр:	Саудын Арабын Вант Улс
Хүн ам:	21 сая
Нийслэл:	Эр-Рияд, Жидда (захиргааны)
Нутаг дэвсгэр:	1,960,580 км ²
Тусгаар тогтносон он:	1291
Үндсэн хууль баталсан он:	1874
Засаг захиргааны нэгж:	13 муж
Харьяа газар нутаг:	Байхгүй
Эрх зүйн бүл:	Исламын Шариатын эрх зүйд тулгуурладаг ¹²⁹

ТӨРИЙН ТОГТОЛЦОО

ХУУЛЬ ТОГТООХ ЗАСАГЛАЛ	ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ	ШҮҮХ ЗАСАГЛАЛ
<p>Парламент</p> <p>(Majlis ash-Shoura)</p> <p>Нэг танхимтай.</p> <p>➤ Зөвлөлдөх танхим</p> <p>Нийт 120 гишүүнтэй. Гишүүдийг 4 жилийн хугацаатай Эзэн хаан томилдог. Эзэн хаанд зөвлөх үүрэгтэй ба гаргасан хууль тогтоомжуудыг Эзэн хаан баталгаажуулна.</p> <p>Орон нутгийн засаг захиргаа</p> <p>Хун тайж болон Эзэн хааны томилсон дээд угсааны гэр бүлээр удирдуулсан 13 мужтай.</p>	<p>Эзэн хаан</p> <p>Угсаа залгамжилсан Эзэн хаан нь төрийн тэргүүн, шашны тэргүүн, Шариатын эрх зүй, Саудын уламжлалыг хадгалах үүрэгтэй. Шүүхийн өршөөл үзүүлэх эрхийг Эзэн хаан хэрэгжүүлдэг.</p> <p>➤ Сайд нарын зөвлөл</p> <p>Дээд угсааны гэр бүлийн гишүүдээс бүрдэх 29 гишүүнтэй, 4 жилийн хугацаатайгаар Эзэн хаан томилно. Тэд Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, бодлого боловсруулах үүрэгтэй.</p> <p>➤ Дээд зөвлөл</p> <p>Удирдагч хун тайж нараас бүрдэх энэхүү зөвлөл нь төрийн хэргийг залгамжлах, тэтгэмж олгох зэрэг асуудлыг нууцаар хэлэлцдэг.</p>	<p>Дээд шүүхийн зөвлөл</p> <p>12 шүүгчдийг Эзэн хааны томилдог. Шүүх ажиллагаанд хяналт тавихаас гадна Шариатын эрх зүйн дагуу шийдвэрлэдэг.</p> <p>➤ Шариатын шүүх (Shari'a Courts)</p> <p>Гэр бүл салалт, хүүхэд асрах эрх, өв залгамжлал зэрэг иргэн, эрүүгийн хэргийг шүүн шийдвэрлэдэг. Шүүгчдийг Эзэн хаан томилдог бөгөөд шүүх ажиллагааг Коран, Суннад үндэслэн явуулдаг.</p>

¹²⁹Дэлхийн улс орнуудын парламент. УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргасан. УБ., 2010 он. 188 дахь тал.